

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 04 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад холбогдох заалтуудын 2023 оны 03 дугаар сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилтийг хамруулсан болно.

Байгууллагын чиг үүрэгт хамаарахгүй буюу үнэлгээнд оруулан тооцох боломжгүй дараах арга хэмжээг хяналтаас хасуулах саналтай байна.

Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд агаарын тээврээр зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авах дэвшилтэд систем /APP/-ийг нэвтрүүлэх, зорчигчийн урьдчилсан мэдээллийг хүлээн авч боловсруулалт хийх, хариу мэдээлэх мэдээллийн төвийг байгуулна.

Үндэслэл: Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаснаар болон Засгийн газрын 2021 оны 261 дүгээр тогтоолоор уг арга хэмжээг холбогдох байгууллагуудад тусгайлан хариуцуулсны дагуу байгууллагын хяналтаас хасуулах саналтай байна.

03 дугаар сард Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилт 30 хувь буюу 1.5 оноотой дүгнэгдлээ.

Хэрэгжилт удаашралтай байгаа нь “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийн хөгжүүлэлтийн асуудлаар 03 дугаар сард гүйцэтгэгч “Аствишн” ХХК-тай 4 удаагийн уулзалт, хурлыг зохион байгуулж, визийн зөвшөөрөл хүсэх, виз, визийн хугацаа сунгах, оршин суух зөвшөөрөл хүсэлт гаргах, хугацаа сунгах, хүчингүй болгох, хэлбэр өөрчлөх, хаягийн өөрчлөлт, бүртгэл, салбар, төлөөлөгчийн газар шинээр байгуулах хүсэлт, сунгалт, хүчингүй болгох программ хангамжийн тестийг хамтарч гүйцэтгэсэн бөгөөд үйл ажиллагаанд нэвтрүүлж эхлээгүй байгаатай холбоотой.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.9-д “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно” зорилтод тусгагдсан “Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ” ажлын хэрэгжилтийг чанаржуулах, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, программ хөгжүүлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, “Аствишн” ХХК-д дэмжлэг үзүүлэн түргэн шуурхай, нягт хамтран ажиллаж байгаа хэдий ч шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг шуурхай хийлгэх, гүйцэтгэгч компаниас ажлын гүйцэтгэлийг шаардах, хяналт тавих, программ хангамжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх, жилийн эцэст зорилт, арга хэмжээний биелэлтийг бүрэн ханган ажиллах шаардлагатай байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
АУДИТЫН ХЭЛТЭС